

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6 – 18
1. <i>“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	7 – 9
2. <i>“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	9 – 13
3. <i>“Ёс зүйн дэд хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	13 – 16
4. <i>“Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргыг чөлөөлөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	16 – 18

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 12 дугаар сарын 30-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 54 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Доржханд, Л.Мөнхбаатар;

Чөлөөтэй: О.Алтангэрэл, Д.Амарбаясгалан, Б.Баярбаатар, Ц.Идэрбат, Ч.Номин, Н.Номтойбаяр, Э.Одбаяр, Б.Пүрэвдорж, Н.Учрал, О.Цогтгэрэл, Ө.Шижир;

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр;

Тасалсан: Л.Оюун-Эрдэнэ.

Нэг. “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхэлсэн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, референт А.Амармэнд, Б.Баясах, Ц.Болормаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүн гараагүй болно.

Ц.Сандаг-Очир: “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхэлсэн газрын зөвлөх Б.Мажигсүрэн, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, референт А.Амармэнд, Б.Баясах, Ц.Болормаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын тавьсан асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхэлсэн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир нар хариулж, тайлбар хийв.

Ц.Сандаг-Очир: “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

***Гурав. “Ёс зүйн дэд хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай”
Байнгын хорооны тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхэлсэн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, референт А.Амармэнд, Ц.Болормаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир Ёс зүйн дэд хорооны даргад нэр дэвшигчийг танилцуулав.

Танилцуулга холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн тавьсан асуултад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн хариулж, тайлбар хийв.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарыг Ёс зүйн дэд хорооны даргаас чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнг тус дэд хорооны даргаар сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 11 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргыг чөлөөлөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхэлсэн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт А.Амармэнд, Ц.Болормаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир “Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргыг чөлөөлөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнг Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргаас чөлөөлөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 11 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 30 минут үргэлжилж, 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр 11 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 54 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Гишүүддээ өдрийн мэндийг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа, Жадамбын Бат-Эрдэнэ, Батын Батбаатар, Жигжидийн Батжаргал, Жудагийн Баярмаа, Энхбатын Болормаа, Сандагийн Бямбацогт, Амгаланбаатарын Ганбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн, Сархадын Зулпхар, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Цэндийн Сандаг-Очир, Цэвэгдоржийн Туваан, Гончигдоржийн Уянгахишиг, Бадарчийн Хэрлэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Доржзовдын Энхтуяа нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 4 асуудал хэлэлцэнэ.

Нэг.“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хоёр.“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Гурав.“Ёс зүйн дэд хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Дөрөв.“Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргыг чөлөөлөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн 4 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орьё. Гишүүдийг дуудаарай.

**Нэг. “Монгол Улсын Их Хурлын 2026 оны
хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт
хяналт шалгалтын цаглавар батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Нэг. “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийн танилцуулгыг Та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д Улсын Их Хурлын хяналт шалгалт нь төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус гэсэн төрөлтэй байхаар заасан бөгөөд хуулийн 8.6-д Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварыг холбогдох шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхээр заасан.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д Байнгын, дэд хороо цаглаварт тусгуулах саналаа ээлжит чуулганаас завсарлахаас ажлын 10 өдрийн өмнө Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлэх ба нам, эвслийн бүлэг цаглаварт тусгуулах саналаа ирүүлж болохоор заасан.

Төрийн байгуулалтын байнгын хороонд –

- Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ирүүлсэн – 2 санал,
- Өргөдлийн байнгын хорооноос ирүүлсэн – 10 санал,
- Хууль зүйн байнгын хорооноос ирүүлсэн – 4 санал,
- Төсвийн байнгын хорооноос ирүүлсэн – 4 саналыг тус тус тусгаж,
- Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ирүүлсэн 8 саналаас 7 саналыг цаглаварт тусгалаа.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо болон нам, эвслийн бүлгээр санал ирүүлээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тусгайлан заасан хугацаатай тайлан, илтгэл, мэдээллийг цаглаварт тусгалаа.

Мөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг бүх Байнгын хороогоор хэлэлцэхээр цаглаварт тусгалаа.

Ингэснээр хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах, хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх, тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх, төсвийн биелэлтийг хянан шалгах, хяналт шалгалтын бусад асуудлыг хэлэлцэх хүрээнд нийт 45 чиглэл цаглаварт тусгагдлаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Материалыг Та бүхэндээ бас тараасан байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж танилцуулга хийлээ.

Асуулттай гишүүн байна уу? Алга байна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Санал хураалт. “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64.7 хувиар нь санал дэмжигдлээ.

Нэг тайлбар хэлье. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15.1.16-д заасан жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэхээр тов дараалалд тусгагдсан байгаа.

Энэ тайланг өнөөдөр хэлэлцвэл энэ тогтоолын төслөөс хасагдана гэдгийг протоколд бас нэмж тэмдэглүүлье.

Ингээд хоёр дахь асуудалдаа орьё.

Санал, дүгнэлтийг хэнээр танилцуулна. Хэн танилцуулах вэ?

Санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нэгдсэн чуулганд танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Хоёр. “Монгол Улсын Их Хурлын 2026 оны
хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг уншиж танилцуулъя.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг оруулна” гэж, 5.4-д “Төрийн байгуулалтын байнгын хороо дараагийн ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын талаарх нам, эвслийн бүлэг, Байнгын, дэд хороо, хууль санаачлагчийн саналыг нэгтгэн Зөвлөлд танилцуулах бөгөөд Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, цаашид “тогтоолын төсөл” гэхийг боловсруулан нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар тогтоолын төслийг батална” гэж тус тус заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооноос “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төслийг боловсруулах явцад хууль санаачлагчаас ирүүлсэн саналыг танилцуулъя. Үүнд:

1. Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс 24, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс давхардсан тоогоор 100 хууль тогтоомжийн төслийг хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудалд тусгуулахаар санал ирүүлсэн.

2. Улсын Их Хурлын Байнгын хороодоос –

- Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо – 2,
 - Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо – 1,
 - Төрийн байгуулалтын байнгын хороо – 5,
-

- Төсвийн байнгын хороо – 2,
- Хууль зүйн байнгын хороо – 6
- Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо – 4,
- Эдийн засгийн байнгын хороо – 3 санал тус тус ирүүлсэн.

Тогтоолын төслийг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан болно.
Үүнд:

1.Хаврын ээлжит чуулганаар хэлэлцэн батлахаар хуульд тусгайлан заасан хууль тогтоомжийн төслүүд.

2.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлгийн шатад байгаа төслүүдээс эхний ээлжид хэлэлцүүлэхээр холбогдох Байнгын хороодоос санал ирүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг тогтоолын төсөлд нэрлэн тусгах зарчмыг баримталж нийт 26 хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцүүлэхээр Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Та бүхэнд тараасан болно.

Түүнчлэн хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухай бүрд шийдвэрлэж байхаар тогтоолд тусгав.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Танилцуулгыг хийж дууслаа.

Тогтоолын төсөл тараасан байгаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан гишүүд асуулт асууна. Асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг цугтаа юм байна. Байхгүй юу? Байхгүй байна.

Ж.Батжаргал гишүүн байна. Ж.Батжаргал гишүүнээр тасаллаа. Ж.Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Тэгэхээр хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөн дотор Улсын Их Хуралд өргөн баригдаад хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн Баялаг бүтээгчдийг дэмжих багц хууль гэж нэг хуулийн төслүүд яваад байгаа юм. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, Төлбөрийн чадваргүйжилтийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль гээд үнэхээрийн бас бид энэ хуулиудыг шуурхай

хэлэлцэж батлан гаргаж, тэгээд энэ улс орны эдийн засгийн идэвхжил, тэлэлтийг нэмэгдүүлэх, баялаг бүтээгчдийн нуруун дээр очоод байгаа татварын ачаалал юмыг бууруулах чиглэлээр тарифын бус хүндрэл саадуудыг арилгах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүд авч байж улс орны эдийн засаг, нийгмийн амьдрал урагшлах өргөн боломж бүрдэнэ гэж үзэж зориуд хаврын чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд нэр зааж оруулахаар санал хүргүүлсэн юм.

Тэгээд энэ асуудал яагаад яг нэрээрээ орж өгсөнгүй вэ? Ер нь энэ асуудлыг нэмээд оруулах бололцоо байна уу гэдэг асуудал байна.

Ц.Сандаг-Очир: Ахлах зөвлөх Б.Хатантуул хариулт өг дөө.

Б.Хатантуул: Байнгын хорооны гишүүдэд энэ өглөөний мэндийг хүргэе.

Тогтоолын төслийг боловсруулахдаа Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс ирүүлсэн 24, Ардчилсан намын бүлгээс давхардсан тоогоор 100, бусад байнгын хороодуудаас ирүүлсэн саналыг хуульд тусгайлан заасан хугацаатай болон өргөн мэдүүлсэн хуулиудыг нэр зааж оруулсан.

Бусад шатны хуулийн төслүүд 2 дахь заалтаараа шийдэгдээд явж байгаа.

Ц.Сандаг-Очир: Ж.Батжаргал бүлгийн даргын асуусантай холбогдуулаад сая тайлбар хэллээ.

Тухай бүрд нь хэлэлцүүлээд явах, 5-ын долоогоороо хэлэлцүүлээд явах бололцоо боломж нь байгаа. Яг хуулийнхаа нэр томъёоллоор өргөн баригдсан хэлэлцэх асуудлаа хийсэн, шийдвэрлэгдсэн хуулиудын төслүүд тогтоолын төсөлд нэр томъёогоор ороод ирсэн байгаа гэдгийг бас хэлье.

Тодруулъя. Ж.Батжаргал гишүүн, бүлгийн дарга.

Ж.Батжаргал: Тийм. Их Хурлын хаврын чуулган руу иргэд олон түмэн анхаарлаа хандуулж байгаа.

Тийм учраас хэдүүлээ хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, ажлын хэсгүүдээ байгуулсан. Яах аргагүй баялаг бүтээгчдийг дэмжих, тарифын хийгээд тарифын бус хүндрэл, саадуудыг арилгах, тэгээд эдийн засгийн идэвхжилт, тэлэлтийг нэмэх чиглэлд хуулиудаа нэр заагаад оруулсан нь дээр. Би тэгж ойлгож байна.

Тэртээ тэргүй чуулганы завсарлагааны хугацаанд ажлын хэсгүүд өргөн хэлэлцүүлгүүд зохион байгуулж, хуулийн төслүүдийнхээ боловсруулалтын түвшнийг улам сайжруулаад, тэгээд хаврын чуулганы эхэн дээр энэ хуулиудыг баталж авч хэрэгжилтийг нь хангаж эхлэх юм бол бодитой үр дүнгүүд гарна л гэж харж байна.

Тийм учраас тэр Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, Төлбөрийн чадваргүйжилтийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулиа нэр зааж оруулах нь зүйтэй гэж үзээд байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Уг нь Ж.Батжаргал гишүүний яриад байгаа зөв л дөө.

Гэхдээ бид таны яриад байгаа наад баялаг бүтээгчдийг дэмжих, бизнесийн эрх чөлөөг дэмжих, хувийн хэвшлийнхний төрийн оролцоог бууруулах гээд энэ агуулга бүхий багц хуулиуд бүгдээрээ сая хэлэлцүүлгийг нь хийлээ. Хэлэлцэх эсэхийг нь чуулганаар.

Тэгээд бүгд хаврын чуулганаар орно. Дампуурлын тухай хууль. Тийм ээ. Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль гээд бүгд. Нэр томъёогоороо ороогүй байна.

Та яг нэр томъёогоор нь оруулж өгье гэж яриад байгаа юм байна. Тийм үү.

Зөвхөн бизнесийн эрх чөлөөтэй холбоотой хуулиудыг нэр томъёог нь оруулна гэвэл цаашид өргөн мэдүүлсэн бүх хуулиудыг нь нэр томъёогоор нь оруулах хэрэгцээ шаардлага үүсээд байгаа байхгүй юу. Энэ хэдэн багц хуулиудыг.

Тэгэхээр маш олон урт 70, 80 жагсаалт орж ирэх гээд байна.

Тэгэхээр хэлэлцэх эсэхээ хийсэн хуулиудыг тэртээ тэргүй хаврын чуулганаараа хэлэлцээд явах учраас яг нэг бүрчлэн нэр томъёогоор нь оруулаагүй байгаа юм гэдгийг хэлье. Шаардлагатай үед тэртээ тэргүй бид хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулаад л батлаад л явдаг.

Тэгэхээр горимын санал хураалгах уу, яах вэ? Тийм, тийм.

Тэгэхээр эдийн засгийн эрх чөлөөтэй холбоотой маш олон хуулиуд сая чуулган дуусах үеэр өргөн баригдаад хэлэлцүүлэг нь хийгдсэн. Энэ хуулиуд бүгд хаврын чуулганаар хэлэлцээд эхэлнэ.

Тэгэхээр Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль, өөр чинь өмчийн хуулиуд байна, төрийн өмчийн компаниудын хувьчлалын асуудлууд байна гээд энэ болгон хаврын чуулганаар хэлэлцэнэ.

Энэ хуулиуд иргэд хэрвээ хэлэлцэх асуудлын жагсаалтыг нь харвал эд нар нэр томъёогоороо ороогүй байна, чухал асуудлууд нь нэр томъёогоороо ороогүй байна гэж Та хэлэх гээд байна шүү дээ. Тийм ээ.

Тийм учраас энэ асуудлууд бүгд хаврын чуулганаараа намрын чуулганаар хэлэлцэх эсэхийг нь хийсэн. Хаврын чуулганаар үргэлжлүүлээд хийгдэнэ ээ гэдгийг Та бүхэнд хэлье.

Тухайн үед нь өргөн баригдсан хуулиудыг оруулах, хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзвэл 5.7-гоор Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцээд батлаад тухайн үед нь шийдээд явах бололцоо боломж нь байгаа гэдгийг бас хэлье.

Тэгвэл ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалтдаа бэлдье.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

17 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 70.6 хувиар санал дэмжигдлээ.

Гурав. “Ёс зүйн дэд хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай”

Байнгын хорооны тогтоолын төсөл

Гурав дахь асуудалдаа орёе. “Ёс зүйн дэд хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Ёс зүйн дэд хорооны даргад нэр дэвшигчийг танилцуулна.

Хаврын чуулганы хэлэлцэх асуудлын санал, дүгнэлтийг хэн чуулганд танилцуулах вэ? Танилцуулах хүн. Ч.Лодойсамбуу гишүүн чуулганд танилцуулна. Байнгын хорооны санал, дүгнэлтийг.

2025 оны 11 сарын 19-ний өдөр Улсын Их Хурлын дэд дарга Жадамбаагийн Бат-Эрдэнэ Танаа гэж байгаад Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүйн дэд хорооны дарга Б.Баярбаатар дарга албан тоотоор Монгол Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хорооны даргын үүрэгт ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт байгаа тул холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэж өгнө үү гэсэн албан тоотоо ирүүлсэн байгаа юм.

Үүнтэй холбогдуулаад Ёс зүйн дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Хэрлэнгийн нэрийг танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Хэрлэн нь Архангай аймгийн Цэцэрлэг хотын 10 жилийн 1 дүгээр дунд сургуулийг төгсөж, 1989 онд Оросын

Холбооны Улсын Иркутск хотын Улсын багшийн дээд сургуульд сурган, сэтгэл судлалын багшийн мэргэжил эзэмшсэн.

-1997 онд Удирдлагын академид Бизнесийн удирдлагын менежер, магистр,

-2003 онд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Подстамы Их сургууль, Төрийн удирдлагын магистр,

-2013 онд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Подстамын их сургуульд Улс төрийн шинжлэх ухааны докторын зэргийг тус тус хамгаалсан.

Бадарчийн Хэрлэн нь 1989-1995 онд Хотын Боловсролын газар мэргэжилтэн, арга зүйч, 1997-2007 онд Удирдлагын академид ахлах багш, 2007-2008 онд Удирдлагын академийн зөвлөгөө өгөх төвийн эрхлэгч, 2013 оноос Удирдлагын академид дэд профессороор тус тус ажиллаж байсан.

Бадарчийн Хэрлэн нь 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

2016 онд Алтан гадас одон, 2021 онд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдсан.

Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Хэрлэн парламентад ажилласан байдал, боловсрол, мэдлэг, туршлага зэргийг харгалзан үзэж Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хорооны даргад санал болгож байна. Монгол Ардын намын бүлгээс.

Танилцуулгыг хийж дууслаа.

Танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Нэрээ өг. Энхбатын Болормаа гишүүнээр тасаллаа. Э.Болормаа гишүүний микрофоныг өгье.

Э.Болормаа: Ингээд бүгдэд нь өдрийн мэнд.

Тэгээд Б.Хэрлэн гишүүндээ Ёс зүйн дэд хорооны даргаар нэр дэвшиж байгаад нь баяр хүргээд, бас эмэгтэй хүн байгаад нь бас баяр хүргээд нэг юм тодруулаад асууя гэж бодож байна.

Ер нь ордон доторх ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой асуудал дээр Та ямар байр суурьтай байх вэ? Энэ дээр ер нь Ёс зүйн дэд хороо яаж ажиллах ёстой гэж үзэж байна вэ гэдэг дээр өөрийн байр суурийг тодруулаад асууя.

Ц.Сандаг-Очир: Б.Хэрлэн гишүүн Э.Болормаа гишүүний асуултад хариулъя.

Б.Хэрлэн: Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүний ёс зүйтэй холбоотой асуудал нэгдүгээрт Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн хүрээнд, цаашилбал төрийн албан хаагчийн ёс зүйн хуулиар ерөнхийдөө зохицуулагдаж явна.

Тэгэхээр эрх зүйн баримт бичгүүдэд ажлын байран дээрх ёс бус үйлдлийн талаар нэлээн нарийн сайн зохицуулалтууд туссан байдаг.

Тэгэхээр хууль зарчмыг барьж бид энэ асуудалд хандах ёстой гэж бодож байна.

Ц.Сандаг-Очир: Э.Болормаа гишүүн тодруулга. 1 минут.

Э.Болормаа: Яах вэ, бодит нөхцөл байдал нь хангалтгүй л байгаа. Та мэдэж байгаа.

Төрийн албан дотор ч гэсэн. Би зөвхөн ордон дотор гэхээсээ илүүтэйгээр Та сая төрийн албаны хуулиараа энэ зохицуулагддаг гэж байна. Маш олон эмэгтэйчүүд над дээр ирж байсан. Ер нь. Өмнө нь аймгийн даргаар ажиллаж байхад ч тэр, одоо гишүүнээр ажиллаж байхад ч тэр. Төрийн албан доторх ажлын байрны бэлгийн дарамт гэдэг зүйлийг Төрийн албаны зөвлөлд гомдол хэлээд ч нэмэр алга гэж байна.

Тэгэхээр таны энэ хариултад би эмэгтэй хүнийхээ хувьд энэ дээр илүү манлайлал үзүүлж ажиллаасай гэж хүсмээр байна. Зүгээр энэ байгаа учир, ингээд хууль дүрмийнхээ дагуу биш, яаж энэ хууль дүрмээ зөв хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажиллаад, тэгээд би танаас тодруулах нь. Одоо энэ том том эрэгтэй гишүүд, дарга нар ийм асуудалд ороход Та энэ дээр хариуцлага тооцож чадах уу?

Ц.Сандаг-Очир: Б.Хэрлэн гишүүний микрофоныг өгье. Хариулт.

Б.Хэрлэн: Тэгэхээр хууль дүрэмд яг иймэрхүү зөрчилд ямар хариуцлага тооцохоор заасан байна тэр дагуу зохих арга хэмжээг аваад явах нь энэ ажил, албан тушаалыг хашиж байгаа хэний хувьд үндсэн үүрэг нь гэж бодож байна. Нэг талаасаа. Нөгөө талаасаа энэ дээр сая хувь хүний манлайллын тухай ярьж байна.

Тэгэхээр хууль тогтоох түвшинд ажиллаж байгаа Улсын Их Хурлын гишүүд мэдээж хэрэг өөрсдийнхөө биеэ авч явах соёлоороо үлгэрлэл, манлайллыг үзүүлэх ёстой,

Тэгээд энэ талын зарчмын шаардлагыг ер нь тавьж ажиллана.

Ц.Сандаг-Очир: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалтад бэлдье.

Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатарыг Ёс зүйн дэд хорооны даргаас чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Хэрлэнг тус дэд хорооны даргаар сонгохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64.7 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

Байнгын хорооны тогтоолыг танилцуулъя.

“Дэд хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10, 27.11 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатарыг Ёс зүйн дэд хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Хэрлэнг Ёс зүйн дэд хорооны даргаар сонгосугай.

Төрийн байгуулалтын байнгын хороо гэсэн тогтоолын төсөл байна.

Гурав дахь асуудлыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Дөрөв.”Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргыг чөлөөлөх тухай”

Байнгын хорооны тогтоолын төсөл

Дөрөв дэх асуудал. Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргыг чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцье.

Дэгийн тухай хуулийн 25.8-д Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны даргаар ажиллахгүй гэсэн байгаа.

Тэгээд Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны дарга М.Бадамсүрэн гишүүн маань Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны сайд болсонтой холбогдуулж, мөн Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүнээс чөлөөлсөн байгаа учраас өнөөдрийн хуралдаанаар М.Бадамсүрэн гишүүний Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсөн асуудлыг хэлэлцэж байгаа шүү гэдгийг хэлье.

Дэд хорооны даргыг чөлөөлөх тухай тогтоолын төслийг уншаад танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг 27 дугаар зүйлийн 27.9, 27.10, 27.11 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэнг Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргыг үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Санал хураалтад бэлдье. Гишүүд.

Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэнг Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргаас чөлөөлөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

17 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 52.9 хувиар Ж.Батжаргал гишүүнийг дэмжсэнд тооцоорой протоколд тэмдэглүүлье.

Ингээд бүлгээс дараагийн Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргын асуудлыг бас яаралтай оруулж ирэх хэрэгтэй болж байгаа байх гэдгээ хэлье.

Ингээд өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

Энэ оны бараг отгон хуралдаан байх. Намрынхаа чуулганд идэвхтэй оролцдог нийт гишүүддээ.

Ж.Баярмаа гишүүнээс эхлээд хэлье. А.Ариунзаяа гишүүн, Ч.Лодойсамбуу гишүүн, Э.Болормаа гишүүн, Б.Хэрлэн гишүүн, С.Зулпхар гишүүн, Г.Уянгахишиг гишүүн, А.Ганбаатар гишүүн, Д.Энхтуяа гишүүн, Л.Энх-Амгалан гишүүн, Ц.Даваасүрэн гишүүн, Ж.Батжаргал гишүүн, С.Бямбацогт гишүүн гээд Төрийн байгуулалтын байнгын хорооны чуулгандаа идэвхтэй оролцдог, Ц.Туваан гишүүн бас байгаа шүү. Б.Баярбаатар гишүүн бас байдаг.

Ингээд идэвхтэй оролцдог гишүүдийг нь бас нэрийг нь хэлэх нь зөв байх. Шударга ёсонд нийцэх байх гэж бодож байна.

Ирэх хаврын чуулганд бас суудаггүй гишүүд хаврын чуулгандаа ирц өндөртэй суумаар байна гэдгийг бас анхааруулж хэлмээр байна.

О.Шижир гишүүнээ бас хэлэх ёстой. Үлдсэн гишүүд нь суудаггүй ээ гээд ойлгочхоорой. Тийм. Ямар ч гэсэн суудаг гишүүддээ талархал илэрхийлье. Тийм. О.Алтангэрэл гишүүн суудаг гишүүдийн нэг шүү. Өнөөдөр л чөлөөтэй байгаа учраас.

Ингээд бүгдэд нь Улсын Их Хурлын намрын чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны отгон хуралдаандаа хүрэлцэн ирсэнд баярлалаа. Хэлэлцэх асуудал дууслаа. Өнөөдрийн байнгын. Хороо хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 30 минут үргэлжилж, 11 цаг 24 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД